



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 201

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын цахилгаан холбоо" хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 213,645,772.73 (хоёр зуун арван гурван сая зургаан зуун дөчин таван мянга долоон зуун далан хоёр төгрөг далан гурван мөнгө) төгрөгийн балансын үнэ, 37,030,437.50 (гучин долоон сая гучин мянга дөрвөн зуун гучин долоон төгрөг далан мөнгө) төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг "Засгийн газрын авто бааз" төрийн өмчит үйлдвэрийн газар, "Сэлэнгэ-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад тус тус шилжүүлсүгэй.

2. "Монголын цахилгаан холбоо" хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Алтан-Очир болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001706

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн
201 дугаар тогтоолын хавсралт



"МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО" ХК-ИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР, "СЭЛЭНГЭ-АЗЗА" ТӨХК-Д
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Автомашин нэр, улсын дугаар, марк	Ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Лексус-570, 25-19 УНЛ (арал-jtjhy7ax9d4114641)	2013	181,727,272.73	181,727,272.73	146,294,605.18	35,432,667.55	"Засгийн газрын авто бааз" ТӨҮГ
2	Ниссан мурано, 53-07 УБУ (арал-jnbaz08w76w518698)	2011	31,918,500.00	31,918,500.00	30,320,730.05	1,597,769.95	"Сэлэнгэ-АЗЗА" ТӨХК
	Нийт дүн			213,645,772.73 (хоёр зуун арван гурван сая зургаан зуун дөчин таван мянга долоон зуун далан хоёр төгрөг далан гурван мөнгө)	176,615,335.23 (нэг зуун далан зургаан сая зургаан зуун арван таван мянга гурван зуун гучин таван төгрөг хорин гурван мөнгө)	37,030,437.50 (гучин долоон сая гучин мянга дөрвөн зуун гучин долоон төгрөг тавин мөнгө)	